

СЭТГҮҮЛИЙН ХААНААС Ч СИТИ SCIENCE СЭТГҮҮЛИЙГ DOI ДУГААРААР УНШИХ БОЛОМЖТОЙ

2025 оны I сар

77442244

info@citi.edu.mn

www.citi.edu.mn

CITI University

NEWS

“БИДНИЙ БАХАРХАЛ” “ОЮУТНЫ ТАЛБАР” “СИТИ БРЭНД” “CONGRATULATIONS” “СИТИ СПОРТ”
“МАНАЙ БАГШ” “НОМ ЯРЬЖ ӨГЬЕ” “СИТИ NEWS” “АМЖИЛТЫН ТҮҮХ”

“МАНАЙ БАГШ”

Ж.ТЭМҮҮЖИН: ДЭЛХИЙН ХААНААС Ч СИТИ SCIENCE СЭТГҮҮЛИЙГ DOI ДУГААРААР УНШИХ БОЛОМЖТОЙ

“СИТИ” Их сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал, доктор (Sc.D), профессор Ж.Тэмүүжинтэй ярилцлаа.



CITI Science эрдэм шинжилгээний сэтгүүлийг 2021 оноос эрхлэн гаргаж эхэлсэн. Улмаар олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл

“СИТИ” Их сургууль эрдэм шинжилгээний CITI SCIENCE сэтгүүлийг эрхлэн гаргадаг. Энэхүү сэтгүүл олон улсад ч бүртгэлтэй болсон байна лээ. Сэтгүүлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч?

“СИТИ” Их сургууль эрдэм шинжилгээний ажлыг чанаржуулах, судалгааны үр дүнг олон улсын түвшинд баталгаажуулах, хийгдсэн судалгааны ажлаа олон нийт, эрдэм шинжилгээ судалгаа гүйцэтгэгч бусад судлаачидтай хуваалцах зорилгоор шинжлэх ухааны судалгаа, үр дүнгийн мэтгэлцээний талбар болох

болохын тулд 2023 онд сэтгүүлийн редакцийн зөвлөл, сэтгүүлийн бодлого, өгүүлэл бичих зааврыг шинэчлэн боловсруулсан. Тухайлбал, гадаадын нэр хүндтэй гурван эрдэмтнийг редакцийн зөвлөлд урин оролцуулж, өгүүлэл монгол хэлээр бичигдсэн ч заавал англи хэлээр хураангуй бичдэг, зураг болон хүснэгтийн тайлбарыг англи хэлээр оруулдаг, холбоо барих зохиогчдын ORCID-ыг оруулдаг болсон.

Ингээд 2024 оны анхны дугаараас эхлэн crossref.com бүртгэлийн системд бүртгэгдэн албан ёсоор DOI дугаар авч crossreference бүртгэлийн системд холбогдсон сэтгүүл болсон. Одоо дэлхийн хаанаас ч DOI дугаараараа уг өгүүлийг унших бүрэн боломжтой болсон. Энэ нь манай сэтгүүл олон улсад хүлээн

зөвшөөрөгдөх эхний алхам бөгөөд бүтээлээс эшлэл авах боломжийг сайжруулан урт хугацаанд бүтээл хадгалагдах юм. Манай сэтгүүлийн DOI дугаарын өмнөх хэсэг www.doi.org/10.60167 гэж бичигддэг.

“Сургуулийн эрдэм шинжилгээний үйл ажиллагаа ямар чиглэлүүдэд түлхүү анхаардаг вэ?”

“СИТИ” Их сургуулийн бүрэлдэхүүн сургууль тус бүр эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлээ тодорхойлсон байдаг. Үүн дээр нэмэгдээд бид тогтвортой хөгжлийн бодлого, зорилтод нийцсэн тэргүүлэх чиглэлийг ахин боловсруулах гэж байна. Хог хаягдлын менежментийн судалгаа хөгжил, хотын хөгжил дээр түлхүү анхаарах төлөвлөгөөтэй байна.

Төгсгөл нь VI нүүрт ▶

“СИТИ” ИХ СУРГУУЛИЙН 2024 ОНЫ ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ

- 01 “СИТИ” Их сургууль 2024 онд Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлөөр 3 дахь удаагаа магадлан итгэмжлэгдлээ. Манай сургууль өмнө нь 2005, 2010 онд магадлан итгэмжлэгдэж байсан билээ.
- 02 “СИТИ” Их сургуулиас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээ, судалгааны “СИТИ SCIENCE” сэтгүүл crossref.com бүртгэлийн системд бүртгэгдэн, албан ёсоор DOI дугаартай боллоо. Хүмүүн хорвоо нийгэмлэг, Нэпко хэвлэлийн газраас эрхлэн гаргадаг “Түүхэн эрхмүүдийн цади” цувралд, “СИТИ” Их сургуулийн анхны Удирдах зөвлөлийн дарга, Монгол Улсын Гавьяат хуульч Д.Дэмбэрэлцэрэн агсны намтар, түүхийн ном хэвлэгдэв.
- 03 “СИТИ” Их сургууль Франц улсын Ницца хотын Côte d’Azur-ийн их сургуультай хамтран “Эрасмус” олон улсын оюутан солилцооны төсөл (2024-2027) хэрэгжүүлж эхэллээ.

- 05 Багш, сургуулийн өмнөх боловсрол, Багш, гадаад хэлний боловсрол (англи хэл), Сувилахуй, Багш, хөгжмийн боловсрол бакалаврын хөтөлбөрүүд магадлан итгэмжлэгдлээ.
- 06 “СИТИ” Их сургуулийн дэргэд Монголын хамгийн анхны силикон гоо сайхны протезын лаборатори байгуулагдлаа.
- 07 “СИТИ” Их сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал, доктор, профессор Ж.Тэмүүжин дэлхийн топ 2%-ийн судлаачдын жагсаалтад багтлаа. Энэхүү нэр хүндтэй үнэлгээ нь дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, олон улсын судалгааны бүтээлийг үнэлдэг Стэнфордын их сургуулиас гаргадаг жагсаалтад тулгуурладаг юм.
- 08 “СИТИ” Их сургуулийн CITI CAMPUS NEWS сонин гарч эхэллээ. СИТИ “Аянга” баг сагсан бөмбөгийн Оюутны лигийн аварга болж, 4 дэх удаагаа үндэсний аварга боллоо.
- 09 “СИТИ Аянга” волейболын шигшээ баг байгуулагдлаа.
- 10

“ОЮУТНЫ ТАЛБАР”

“СИТИ” ИХ СУРГУУЛИЙН ЭРХЭМ ОЮУТАН ЗАЛУУС АА!

“СИТИ” Их сургуулийн эрхэм оюутан залуус та бүхэнд өөрийн үзэл бодлоо олон нийтэд хүргэх, сэтгэн бодох, бичих ур чадвараа нээх гайхалтай боломжийг CITI CAMPUS NEWS олгож байна. Шинэлэг санал санаачилга, сонирхолтой мэдээ мэдээлэл, нийтлэлүүдээ бусдад хүргэхийг хүсч байвал бидэнтэй нэгдээрэй. “СИТИ” Их сургуулийн оюутан бүрт бидний үүд хаалга нээлттэй.

“БИДНИЙ БАХАРХАЛ

Э.МӨНХТУЛГА: 2025 ОНД ИРВЭС, БАРЫН ХЭЭ, ЭРЧИЛЖ, ТУНАРСАН ЗАГВАРТАЙ ПЛАЖ ТРЭНД БОЛНО



“СИТИ” Их сургуулийн Архитектур Дизайны сургуулийн Хувцас дизайны IV курсийн оюутан, Монгол модел агентлагын модел Э.Мөнхтулгатай ярилцлаа.

шалтгаан юу вэ гэдгээс ярилцлагаа эхэлье.

“Миний хувьд дизайнд сонирхолтой учраас суралцах сургуулиа нэлээд судалж сонгосон. Ингээд хувцас дизайны чиглэлээр олон жил элсэлт авч, чадварлаг багш нараар бүрдсэн “СИТИ” Их сургуулийг сонгосон. Түүнээс гадна сургуулийн сургалтын орчин надад маш их таалагдсан.

“Таны хувьд хичээлийнхээ хажуугаар загвар өмсдөг. Завгүй өдрүүд өнгөрдөг болов уу гэж харж байна. Юуны өмнө “СИТИ” Их сургуулийг сонгох болсон

Төгсгөл нь II нүүрт ▶

“ТӨГСӨГЧИЙН АМЖИЛТЫН ТҮҮХ”

М.МАРЖАН: ХЯТАД ХЭЛ ЯМАР ГОЁ ЮМ БЭ ГЭЖ ДУРЛАЖ СУРСАН ДАА

“СИТИ” Их сургуулийн 2023 оны төгсөгч М.Маржантай ярилцлаа.

-“СИТИ” Их сургуулийг хэдэн онд төгссөн бэ. “СИТИ” Их сургуулийг яагаад сонгох болсон талаар ярилцлагаа эхэлье?

-Би “СИТИ” Их сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн Хятад хэлний орчуулагчийн ангийг 2023 онд төгссөн. “СИТИ” Их сургуулийг сонгосон хэд хэд шалтгаан бий л дээ. Нэн тэргүүнд хятад хэлний багш Ш.Мөнхцэцэг болон энэ сургуульд суралцаж байсан найзуудаасаа мэдээлэл авах зэргээд сургуулиа сонгосон.

-Одоо БНХАУ-д суралцаж байгаа гэсэн. Ямар мэргэжлээр суралцаж байна вэ?

-Би одоогоор БНХАУ-ын Шанхай хотын EAST CHINA NORMAL UNIVERSITY-д Art design чиглэлээр магистр хамгаалахаар суралцаж байна.

-Оюутан байх хугацаандаа гаргасан амжилтуудаа дурдаач?

-Би хичээлээс гадуурх урлаг соёлын тэмцээнүүдэд их оролцдог байлаа. 2022 онд оюутан байхдаа “汉语桥” олон улсын хятад хэлний тэмцээний “Улсын аварга” болон “Шилдэг үзүүлбэртэй” оролцогчоор шалгарч байсан. Мөн үргэлжлүүлээд финал шатандаа “Азийн шилдэг 8”-д шалгарч байсан зэрэг маш олон шагналыг оюутан байх хугацаандаа ч тэр одоо ч тэр хүртэж явна.

-Хятад хэлний орчуулга хийхэд хамгийн чухал чадварууд юу вэ?

-Хятад хэлний орчуулга хийхэд хэлээ сайн эзэмшсэн байхаас гадна зөв дуудлага маш чухал юм. Хэлээ хичнээн сайн мэддэг байлаа ч буруу



дуудлага, аялгаар яривал бусдад буруу ойлгогдох магадлалтай байдаг. Тэр тусмаа хятад хэл өөрөө зөв дуудлага шаарддаг хэл.

-Хятад хэлний орчуулагчийн хувьд хамгийн чухал судалгаа, ном эсвэл эх сурвалж юу байсан бэ?

-Хятад хэлний орчуулагчийн хувьд мэргэжлийн хэллэгийн толь бичиг, хэлц үгний толь бичиг хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг юм шиг санагддаг. Хятад хүмүүс хэлц үг ашиглаж ярих их дуртай байдаг.

-Та орчуулгын үр чадваруудаа хөгжүүлэхийн тулд ямар арга барил, дадал зуршлыг хэвшүүлсэн бэ?

-Би анх хятад хэл сурч эхэлсэн цагаасаа тв шоу их үздэг байсан. Үзэж буй зүйлээсээ өдөр тутмын хэллэг, мэргэжлийн үг хүртэл сурах 100 хувь боломжтой байдаг. Дуртай

“БИДНИЙ БАХАРХАЛ

Э.МӨНХТУЛГА: 2025 ОНД ИРВЭС, БАРЫН ХЭЭ, ЭРЧИЛЖ, ТУНАРСАН ЗАГВАРТАЙ ПЛАЖ ТРЭНД БОЛНО

» Түүрүүч нь I нүүрт

Сургуулиас гадна Монголд хувцас дизайны салбарт танигдсан нэр хүндтэй брэндүүдтэй холбогдох боломж олддог нь бас нэгэн сонгох шалтгаан болсон.

-Суралцах хугацаандаа олон амжилт гаргасан байсан. Амжилтуудаасаа дурдаач?

-Би “СИТИ” Их сургуулийн Хувцас дизайны тэнхимээс зохион байгуулсан “Floraion fashion show” арга хэмжээний “Шилдэг оюутан”, “Graduation show 2022”- Тусгай байр, “Winter fashion show 2023” дэд байр, “Evening gown 2024” III байр тус тус эзэлсэн. Түүнчлэн “СИТИ” Их сургууль “Уушгийн ахуй” ХХК-тай хамтран зохион байгуулсан “Арьс шилэн эдлэл 2025” тэмцээний “Шилдэг загвар” шагналыг хүртсэн.

-Хувцас дизайнаар суралцаж оюутнаас асуулгүй өнгөрч болохгүй нь. 2025 оны хувцас, өнгө, аксессуарын чиг хандлага ямар байх вэ?

-2025 оны хувьд хувцасны чиг хандлагууд шинэлэг, өвөрмөц байх болно. Ирвэс, барын хээ бүхий хэвлэлүүд, эрчилж, тунарсан загвартай плажнууд, минималист, дэрвэгэр сул тунарсан материалтай цамцнууд, цэнхэр шулуун жийнс, арьсан банзал, сагсар ноолууран шүлжмэлүүд болон спортын өнгө

аястай цуглуулгууд тэргүүлэх трэнд болж, моодод орох төлөвтэй байна. Өнгөний хувьд улаан буюу черри өнгө голлох трэнд болж, эрч хүчтэй, тод өнгө төрхийг илэрхийлэх нь.

-Дизайнаа гаргахад зургаа хэр удаан боддог вэ. Санаагаа хэрхэн олж авдаг юм бол?

-Ихэвчлэн толгойд орж ирсэн санаагаа шууд эскиз маягаар буулгадаг. Үүний дараа таалагдсан деталиудыг нэмэн, хасч, загвараа сайжруулан боловсруулдаг. Заримдаа загвараа гаргахдаа судалгаа ч хийдэг. Тухайн цаг үед трэнд болж буй зүйлсээс ч санаагаа олдог.

Түүнчлэн амьдралын өдөр тутмын үйл явдал, байгалийн үзэгдлүүд, урлагийн бүтээлүүдээс ч санаагаа авдаг.

-Та карьерийн талаараа ямар төлөвлөгөөтэй байгаа вэ?

-Үндэсний соёл, түүх нь бидний хувцас дизайны салбарт чухал үүрэг гүйцэтгэх ёстой гэж би боддог. Тиймээс өөрийн бүтээлдээ үндэсний соёл, уламжлалаа аль болох тусгахыг зорьдог л доо. Энэ үүднээс өөрийн бүтээлдээ соёл түүхээ харуулсан хэсгийг их бага хэмжээгээр шингээж таниулахыг зорьж ажиллана гэж боддог.

Ц.ЦЭРЭНБЯМБА


зүйлээ үзэнгээ орчуулгын чадвар гэлтгүй сонсох, ярих, унших, бичих чадвараа сайжруулсан.

-Хятад хэлний орчуулга хийж байхдаа болсон хөгжилтэй, дурсамжтай зүйлээсээ дурдаач?

-Орчуулга хийх бүрдээ ямар нэгэн шинэ зүйл сурч мэдэж, шинэ хүрээлэлд орж, мэдэхгүй зүйлтэйгээ нүүр тулдаг нь дурсамжтай юм болов уу. Тэр бүхнээсээ суралцаж, танин мэдэж байдаг нь сонирхолтой байдаг даа.

-Хятад хэл сурахад тулгардаг бэрхшээлүүдийг хэрхэн давах ёстой талаар манай оюутнуудад зөвлөгөө өгөөч?

-Хятад хэлийг анх 4 хөгтэй байдаг гэдгийг ч мэдэхгүй сурна аа гээд сурч эхэлж байсан. Оюутан болоод хятад хэлийг үзэж эхлээд хятад хэл чинь яасан гоё юм бэ гэж бодон дурлаж сурч байлаа. Одоо ч мөн адил. Хэлтэй бол хөлтэй гэдэг дээ. Эзэмшсэн мэргэжилдээ эзэн нь болж яваарай гэж хэлье.



РЕДАКЦЫН ЗУРВАС

Эрхэм оюутан залуус, багш ажилчид, уншигчдадаа шинэ оны мэнд хүргэе.

“СИТИ” Их сургуулийн “CITI CAMPUS NEWS” сонины гурав дахь дугаар буюу 2025 оны анхны дугаараа та бүхэнд өргөн барьж байгаадаа баяртай байна.

Энэхүү дугаартаа бид олон сонирхолтой ярилцлага, мэдээ мэдээллүүдийг багтаасан бөгөөд “Манай багш” буланд “СИТИ” Их сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал, доктор (Sc.D), профессор Ж.Тэмүүжин сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Түүнчлэн Хувцас дизайны IV курсийн оюутан,

Монгол модел агентлагын модел Э.Мөнхтулга 2025 оны загварын чиг хандлагыг онцолж, ирэх онд ирвэс, барын хээ бүхий хэвлэлүүд, эрчилж, тунарсан загвартай плажнууд, минималист, дэрвэгэр сул тунарсан материалтай цамцнууд трэнд болж, моодонд орох төлөвтэйг дуулгав. Түүнчлэн Хятад хэлний орчуулагчийн ангийн төгсөгч Маржан ярилцлагадаа хятад хэлийг сурахдаа юуг анхаарах талаар ярих. Мөн сургуулийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл, сонирхолтой номыг ч танд санал болгов. Та бүхэн 2025 онд амжилт бүтээлээр дүүрэн байхыг хүсье. Шинэ дугаараа шимтэн уншиж, шинэ мэдээ, мэдээллүүдтэй танилцаарай.

ӨВЛИЙН ЭЛСЭЛТ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

“СИТИ” Их сургуулийн 2024-2025 оны хичээлийн жилийн өвлийн элсэлтийн бүртгэл үргэлжилж байна. Та манай бүрэлдэхүүн сургуулиудад Бакалавр, Магистр, Докторын хөтөлбөрөөр элсэн суралцах боломжтой. Бүртгэл: 2024.12.02–2024.02.05-ныг дуустал үргэлжилнэ. Та бүхэн www.citi.edu.mn болон “СИТИ” Их сургуулийн А байрны 201 тоотод биеэр ирж бүртгүүлэх боломжтой.

"СИТИ СПОРТ"

СИТИ "АЯНГА" БАГ 3 ХОЖИЛТОЙГООР ОЮУТНЫ ЛИГИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЖ БАЙНА




Сагсан бөмбөгийн Оюутны лиг үргэлжилсээр байна. СИТИ "Аянга" багийн тухайд эрэгтэй 1 дүгээр баг 3 хожил 4 хожигдолтой явж байгаа

бол, эрэгтэй 2 дугаар баг 4 хожил 1 хожигдол, эмэгтэй баг 4 хожил 3 хожигдолтой явж байна. Дашрамд дурдахад, 2023-2024 оны

"Оюутны лиг"-ийн аварга СИТИ "Аянга" багийн дундаж өндөр 186.3 см байсан бол дундаж нас 21.5 байжээ.

"CONGRATULATIONS"

"EVENING GOWN-2024" ГОЁЛЫН ДААШИНЗНЫ УРАЛДААНЫ ШИЛДГҮҮД ТОДРОВ



"СИТИ" Их сургуулийн Архитектур-Дизайны сургуулийн Хувцас дизайны тэнхимээс Хувцас дизайны I-IV курсийн оюутнуудын дунд зохион байгуулсан "Evening Gown-2024" гоёлын даашинзны уралдаан амжилттай болж өндөрлөлөө.

Шагналт байрын эзэд:

I байр - Хувцас дизайны III курсийн оюутан Г.Сүнжидмаа
II байр - Хувцас дизайны III курсийн оюутан Х.Тэгшжаргал
III байр - Хувцас дизайны IV курсийн оюутан Э.Мөнхтулга нар тус тус шалгарлаа.

"СИТИ CAMPUS NEWS" СОНИНЫ РЕДАКЦ

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ:

"СИТИ" Их сургууль

ЕРӨНХИЙ РЕДАКТОР:

Б.НОМИН-ЭРДЭНЭ

/"СИТИ" Их сургуулийн маркетингийн менежер/

СЭТГҮҮЛЧ:

Э.БЯМБАСҮРЭН

/"СИТИ" Их сургуулийн Сэтгүүл зүйн IV курсийн оюутан/

Ц.ЦЭРЭНБЯМБА

/"СИТИ" Их сургуулийн Сэтгүүл зүйн III курсийн оюутан/

О.ЭНХСАРАН

/"СИТИ" Их сургуулийн Сэтгүүл зүйн III курсийн оюутан/

ХОЛБОО БАРИХ УТАС:

77442244

ЦАХИМ ХАЯГ:

Nomin-erdene.bazarragchaa@citi.edu.mn

"СИТИ БРЭНД"

Оюутнууд, төгсөгч, багш ажилтан та бүхэнд СИТИ" Их сургуулийн нэрийн бүтээгдэхүүнүүдийг санал болгож байна. Сургуулийнхаа бахархлыг илэрхийлэх нэрийн брэнд бүтээгдэхүүнүүдийг та бүхэн "СИТИ" Их сургуулийн А байрны 2 давхарт байрлах нэрийн брэнд дэлгүүр (Merchandise concept store) -ээс худалдан авах боломжтой. Түүнчлэн халуун кофе, шинэхэн зайрмагийг таньд санал болгож байна.

"МАНАЙ БАГШ"

Ж.ТЭМҮҮЖИН: ДЭЛХИЙН ХААНААС Ч CITI SCIENCE СЭТГҮҮЛИЙГ DOI ДУГААРААР УНШИХ БОЛОМЖТОЙ

» Түрүүч нь I нүүрт

-Оюутан, багш нарыг эрдэм шинжилгээний ажилд хэрхэн оролцуулж, тэдний судалгааны ажлыг дэмждэг вэ?

-Манай сургууль өөрсдийн багш, оюутны эрдэм шинжилгээ судалгааны үйл ажиллагааг дэмжих зорилготой "Суралцагчдын эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, дүгнэх журам", "СИТИ Их сургуулийн эрдэм шинжилгээ, инновацийн журам", "СИТИ Их сургуулийн санхүүжилтээр төсөл хэрэгжүүлэх журам", "СИТИ Их сургуулийн оюуны өмчийн талаар баримтлах бодлого", "СИТИ Их сургуулийн багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийг урамшуулах журам" зэрэг бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. "СИТИ" Их сургууль олон улсын хэмжээнд танигдсан эрдэм шинжилгээний байгууллага болох зорилго тавин ажиллаж байна. **"СИТИ" Их сургууль олон улсын эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлж байна вэ?**

-"СИТИ" Их сургууль нь Европын холбооны санхүүжилттэй Европ, Азийн их сургуулиудыг холбосон Erasmus Mundus mobility with Asia хөтөлбөрийн хүрэн дэх Монгол дахь түнш байгууллагын хувьд хамтран ажиллагч их, дээд сургуулиудтайгаа хөтөлбөрийн хүрээнд бүх талаар хамтран ажилладаг. Үүнээс гадна 2 талын хамтын ажиллагааны

гэрээтэй Сингапур, Малайз, Энэтхэг, Франц, Япон, БНСУ-ын их дээд сургуулиудтай хамтран ажиллаж байна.

-Таны хувьд Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн салбарт томоохон ямар ямар ахиц дэвшлүүд гарсан гэж харж байна?

-Үүнийг ярихын тулд цаг хугааны ямар үетэй харьцуулж байна гэдгийг тодруулах шаардлагатай гэж бодож байна. Эрдэм шинжилгээний бүтээлийн чанар, олон улсад үнэлэгдэх, хүлээн зөвшөөрөгдөх тал дээр үнэхээр илт ялгагдах өөрчлөлтүүд 1990-ээд оноос хойш гарсан. 1992-1993 онуудад олон улсын бүртгэлийн Скопус системд бүртгэлтэй өгүүлийн тоо хоёр, гурваар л тоологдож байсан бол одоо жилд хэдэн зуугаар, эшлэл хэдэн мянгаар нэмэгдэж байна. Судлаачдын тоо 1990 оноос өмнөх үетэй харьцуулахад хэдэн мянгаар буурсан боловч судалгааны үр дүнгийн үндсэн үзүүлэлтийн нэг болох олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх өгүүлийн тоо эрс сайжирсан. Одоо судалгаа шинжилгээний үр дүнг өрсөлдөхүйц патент, шинэ технологи болгон үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх ажиллагаа л олон бодит шалтгаанаас болж санаснаар биелэгдэхгүй байна даа. Түүнчлэн тогтвортой хөгжлийг хангах судалгаа шинжилгээний чиглэлийг хамгийн чухал гэж харж байна. Үүнээс гадна саяхан болж

өнгөрсөн "Шинжлэх ухаан, оролцоо" үндэсний форумд хэлэлцэгдсэн Засгийн газраас хэрэгжүүлэхээр зорьж буй мега төслүүдэд үнэлэлт дүгнэлт өгөх, боломжит мега төсөл хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцох шаардлагатай байна.

-Таны эрдэм шинжилгээний гараа хэрхэн эхэлсэн бэ? Та ямар ямар цол хэргэм хүртэж байсан талаараа яриач?

-Би 1991 оны хавар хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн Украин улсын Киевийн Политехникийн Дээд Сургуулийг Металл бус галд тэсвэртэй силикат материалын химийн технологич мэргэжлээр төгсөж ирээд ШУА-ийн Химийн хүрээлэнд Эрдэм шинжилгээний дэд ажилтнаар орж ажилласан. Монгол орны эрдэм түүхий эдийг боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр ажилласан. Тэгээд 1995 онд Техникийн Их Сургууль (ШУТИС) дээр "Орон нутгын түүхий эдээр цахилгаан тусгаарлах материал үйлдвэрлэх технологийн үндэс" нэг сэдэвт бүтээлээр техникийн ухааны дэд доктор (PhD) зэрэг хамгаалсан. Тэгээд дараа жил нь буюу 1996 онд ЮНЕСКО/МОНБУШО-гийн санхүүжилттэй Химийн инженерчлэлийн 1 жилийн курсад Японы Токиогийн Технологийн Их Сургууль дээр суралцсан. Дараа нь Японы Шинжлэх Ухааныг Дэмжих Сан (JSPS), Английн Вангийн Нийгэмлэг (Royal Soci-

ety, UK), Германы Хумбольдтын сан (A v Humboldt foundation)-ын Постдокторын санхүүжилтээр Токиогийн технологийн их сургууль, Английн Лийдсийн их сургууль, Германы Хамбург-Харбургын техникийн их сургууль дээр судалгаа хийж байсан. Мөн Японы Кейо Их сургуулийн судлаачаар ажиллаж байгаад Монголдоо ирсэн. Тэгээд 2007-2010 онуудад Австралийн Куртины их сургуульд төслийн удирдагч, ахлах багш/эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж байгаад нутагтаа ирсэн. Тэгээд 2011 онд Монгол улсын ШУА-ийн жинхэнэ гишүүн академичаар сонгогдсон. Японы Акиагийн их сургуульд зочин профессороор ажиллаж байсан. Судалгаа шинжилгээнийхээ үр дүнгээр 2015 онд ХБНГУ-ын Хумбольдтын сангын Георг Форстерийн шагналаар, Монгол улсын ШУА-ийн шилдэг залуу судлаачийн шагнал, Италийн Триест хот дахь 3-дагч орнуудын ШУА-ийн (World Academy of Sciences) шилдэг залуу эрдэмтний шагнал, Монгол улсын Боловсрол, шинжлэх ухааны яамны оны шилдэг бүтээлийн тусгай, 3, 2-р байрны шагналуудыг тус тус хүртэж байсан. 2006 онд "Нано бүтэцтэй органик бус материалыг жолоодлоготойгаар гарган авах физик-химийн үндэс" нэг сэдэвт бүтээлээр Химийн шинжлэх ухааны докторын (ScD) зэргийг Монгол улсын ШУА дээр хамгаалсан.

О.ЭНХСАРАН

"НОМ ЯРЬЖ ӨГЬЕ"

ЯПОН ХҮН ГЭЖ ХЭН БЭ?



Энэ удаагийн дугаартаа Сато Чиэ зохиолчийн "Япон хүн гэж хэн бэ?" номыг онцолж байна. Дэлхийн мэдлэгийн үйлдвэр гэж болох Харвардын их сургуульд япон хүнийг арван талаас нь хэрхэн судалж буйг маш сонирхолтой байдлаар энгийн ойлгомжтой үг хэллэг, жишээ татан ярилцлага хэлбэрээр бичсэн энэхүү номноос манай их, дээд сургуулийн багш, судлаачдын хувьд Харвардад судалгааны ямар аргаар гадаад орнуудыг судалж, түүнийгээ

оюутнуудад хэрхэн сонирхолтой байдлаар хүргэж, тэдний мэдлэг, төлөвшилд хэрхэн нөлөөлж буйг энэ номоос мэдэх боломжтой. Тухайлбал "Япон хүн яагаад роботыг анд нөхөр мэт хүлээж авдаг вэ?", "Яагаад япон хүн жижиг гэлтгүй аливаа зүйлд ач холбогдол өгдөг юм бол", "Яагаад бүтээх, цэвэрлэхийг чухалчилдаг юм бол?" зэрэг сонирхолтой асуултуудыг хөндөж, япон хүний соёл, зан заншил, үзэл бодлыг тайлбарладаг.

Энэхүү ном нь дэлхийн оюуны охь болсон Харвардын их сургуулийн 10 профессортой ярилцлага хийж, япон хүмүүсийн өөрсдөө ч анзаарч мэдээгүй гайхамшигийг дахин нээх ном юм.

Бусад улсаас суралцаж байж л өөрийн явцуу хүрэнээс гарч чадна. Либерал артс бол өөрийн хязгаарыг давахад ч, өөрөөсөө өөр соёл, нийгмийн байдлыг мэдэхэд ч зайлшгүй чухал боловсрол билээ. Энэхүү ном нь монголчуудын хувьд

япончуудын тухай мэдэхийг хүсдэг, тэдний талаар гайхаж боддог асуултуудад сонирхолтой хариулт өгөхөөс гадна бидний хүндлэн дээдэлдэг өвөг дээдэс, Чингис хааны ген одоог хүртэл монголчуудад төдийгүй дэлхийн олон орны хүмүүст өвлөгдөн хадгалагдаж буй тухай ч өгүүлэх юм.

НОМЫН САНЧ, МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТАН Б.САЙНТУЛГА

"CITI NEWS"

“БАГШ ХӨГЖМИЙН БОЛОВСРОЛ” БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДЛЭЭ



“СИТИ” Их сургуулийн Урлагийн сургуулийн “БАГШ ХӨГЖМИЙН БОЛОВСРОЛ” бакалаврын хөтөлбөр магадлан итгэмжлэгдлээ. Энэхүү хөтөлбөр нь ирээдүйн

хөгжмийн багш нарыг мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэж, урлагийн салбарт үнэтэй хувь нэмэр оруулах зорилготой юм.

“URBAN ADVENTURE” КЛУБ ЧИНГИС ХААН ҮНДЭСНИЙ МУЗЕЙТЭЙ ТАНИЛЦАВ



“СИТИ” Их сургуулийн Бизнесийн сургуулийн Аялал жуулчлалын тэнхимийн дэргэдэх “Urban Adventure” клуб 2024-2025 оны хичээлийн жилийн ээлжит аяллаа амжилттай зохион байгууллаа. Аяллын хүрээнд Чингис хаан үндэсний музей болон Улаанбаатар хотын түүх, соёлын дурсгалт газруудтай танилцаж, орон нутгийн баялаг өв соёлыг

танин мэдэх үнэ цэнэтэй боломжийг оюутан залууст олгов. Музей үзэх нь нэг боть ном уншсантай дүйцэхүйц өргөн цар хүрээтэй мэдээлэл өгдөг төдийгүй өөрийн орны түүх, соёлыг гүнзгий ойлгох, туршлага хуримтлуулах, мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.

АРХИТЕКТУР ДИЗАЙНЫ ЧИГЛЭЛЭЭР СУРАЛЦАЖ БУЙ ОЮУТНУУД ЭНЭТХЭГ УЛСЫГ ЗОРИЛОО



“СИТИ” Их сургууль гадаад харилцааны хамтын ажиллагааны хүрээнд Энэтхэг улсын VIT (VIT University) их сургуультай хамтран ажилладаг билээ. Тэгвэл 2024 оны 12 сарын 9-ний өдөр Архитектур Дизайны чиглэлээр суралцаж буй оюутнууд маань хоёр долоо хоногийн сургалтад хамрагдахаар Энэтхэг улсыг зориллоо. Энэхүү

сургалт, оюутны байр, хоол, соёлын аяллын хөтөлбөр нь үнэ төлбөргүй бөгөөд оюутнууд Энэтхэг улсын соёл, урлаг, архитектур, дизайны салбарын хөгжилтэй танилцаж, дэлхий нийтийн чиг хандлагууд, үзэл баримтлалын талаар шинэ мэдлэг мэдээлэлтэй болох зэрэг чухал ач холбогдолтой юм.

“БАТЛАН ХАМГААЛАХ ҮЙЛСЭД ОЮУТАН ЗАЛУУС” ТӨСЛИЙН УУЛЗАЛТ БОЛЛОО



Их, дээд сургуулийн оюутнуудад хугацаат цэргийн албаны тухай ойлголт, мэдээллийг өгөх, цэргийн алба хаах хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх, цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилго бүхий “Батлан хамгаалах үйлсэд оюутан залуус” төсөл хэрэгжиж байгаа билээ. Тэгвэл хурандаа С.Тэмүүлэнзаяа, хошууч П.Жавхлантөгс, дэслэгч Б.Эрдэнэбат, ахлагч Э.Аюушбазар

нар “СИТИ” Их сургуулийн оюутнуудад батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаар мэдээлэл өглөө. Түүнчлэн цэргийн хугацаат болон дүйцүүлэх алба, цэргийн гэрээт алба, “Оюутан цэрэг” хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, хуулийн болон практик мэдлэгийг оюутнуудтай хуваалцав.

"CITI NEWS"

ГАДААД ОЮУТНУУД МОНГОЛ ХЭЛНИЙ СЕРТИФИКАТАА ГАРДАН АВАВ



"СИТИ" Их сургуулийн Хүмүүнлэгийн сургууль гадаад оюутанд зориулсан Монгол хэлний "Модуль-1" сургалтаа явуулж, амжилттай дуусгалаа.

Оюутнууд маань шалгалтаа амжилттай өгч сертификатаа гардан авав.

"ҮНСГЭЛЖИН" ДУУРИЙГ БАГШ, ОЮУТНУУДАД ТОЛИЛУУЛАВ



"СИТИ" Их сургууль Франц хэл, соёлын төв Алянс Франсайзтай хамтран 12 сарын 12-нд Жюль Масенегийн "Үнсгэлжин" дуурийг багш, оюутнуудад толилууллаа.

Дуурийн хөгжмийг Жюль Масенет бичиж, Мариам Клемент найруулсан бөгөөд Парисын үндэсний дуурийн театр, Micro-Folie сүлжээ болон цахим музейтэй хамтран бүтээжээ.

ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛТАЙ "ТАНИЛЦАХ ДАДЛАГА" ХИЙЛЭЭ



"СИТИ" Их сургуулийн Бизнесийн сургуулийн Аялал жуулчлалын тэнхимийн дэргэдэх "Urban Adventure" клуб 2024-2025 оны хичээлийн жилийн ээлжит аяллаа зохион байгууллаа. Энэхүү аяллаар Аялал жуулчлал, Агаарын тээврийн үйлчилгээ хөтөлбөрөөр суралцаж буй оюутнууд Чингис хаан олон

улсын нисэх буудалтай "Танилцах дадлага" хийлээ. Энэхүү дадлагыг Бизнесийн сургуулийн Аялал жуулчлалын тэнхимийн эрхлэгч, багш М.Бямбасүрэн, Агаарын тээврийн үйлчилгээний багш Х.Энгүүнзаяа нар удирдан зохион байгууллаа.

"ТАМЫН ДУРЛАЛ" ЭКСПЕРИМЕНТАЛ ЖҮЖИГ АМЖИЛТТАЙ ТОГЛОГДЛОО



"СИТИ" Их сургуулийн Урлагийн сургуулийн Жүжиглэх, найруулах урлагийн тэнхимийн Найруулагчийн IV курсийн оюутнууд Нобелын шагналт зохиолч Южин О'Нилын "Тамын дурлал" экспериментал жүжгийг амжилттай тоглолоо. Жүжгийн найруулагчаар IV курсийн

оюутан Г.Идэрбат ажиллаж, дүрүүдэд энэ курсын оюутнууд хүч үзэж, эмэгтэй дүрд тайзны ярианы багш Э.Анужин тоглосон юм. Найруулагчийн уран чадварын багш, УДЭТ-ын ерөнхий найруулагч, МУУГЗ Ч.Түвшин удирдсан юм.

БАГШ М.ЦОЛМОНСҮРЭН МУХТ-ИЙН УРАН БҮТЭЭЛЧИД, СУИС, "СИТИ" ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНУУДАД ИЛТГЭЛ ТАВИВ



"Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд Улсын хүүхэлдэйн театрын "Онцлох хүн"-ээр МУГЖ Л.Чимэддоржийг онцолж, түүний урлагийн үнэт өвийг олон нийтэд сурталчилан таниулах үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү арга хэмжээнд "СИТИ" Их сургуулийн

Урлагийн сургуулийн Ярих урлагийн тэнхимийн багш М.Цолмонсүрэн "МУГЖ Л.Чимэддоржийн бүтээсэн дүрүүдийн онцлог" сэдвээр МУХТ-ийн уран бүтээлчид, СУИС, "СИТИ" Их сургуулийн оюутнуудад илтгэл тавьж, сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлээ.

"КАЗАХ ҮНДЭСТНИЙ ӨДӨРЛӨГ 2024" БОЛЛОО



"СИТИ" Их сургуулийн Шырах казах оюутны клубээс багш, оюутнууд Казах үндэстний түүх, соёл, ёс заншилтай танилцах өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр казахын уламжлалт хоол, амттануудыг

амталж, үндэсний хувцас, гоёл чимэглэлийг өмсөн зураг авахуулж, Казах үндэстний түүх, урлаг, ёс заншлыг суралцаж, казахын уламжлалт дуу, бүжиг, урлагийг сонирхлоо.

"CITI NEWS"

Б.ОДОНГЭРЭЛ ЗАХИРАЛ ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН БАГИЙГ АХАЛЖ БАЙНА



"СИТИ" Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, доктор, дэд профессор Б.Одонгэрэл ГХУСАЗЗАА-ны захиалгаар Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах ажлын багийг ахлан ажиллаж байна. Ийнхүү төслийг холбогдох албан тушаалтнуудад танилцуулжээ. Энэ үеэр Хүн худалдаалахтай тэмцэх тухай болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан

сэргийлэх үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, хуулиар үүрэг хүлээсэн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр боловсруулсан дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлсэн байна. Хэлэлцүүлэгт Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн гишүүд болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл оролцжээ.

ШИНЭ НОМЫН ҮЗЭСГЭЛЭН ГАРЛАА



"СИТИ" Их сургуулийн номын сангаас өнөөдөр олон төрлийн ном, сурах бичиг, сэтгүүл, эрдэм шинжилгээний материалыг агуулсан шинэ номын үзэсгэлэнг танилцууллаа. Энэ үеэр Номын сангийн Электрон каталоогоос хэрхэн ном, сурах бичиг, сэтгүүл зэрэг материалыг хайх талаар багш, оюутнуудад мэдээлэл өгч, тэдэнд илүү хялбар, үр дүнтэй номын сангийн үйлчилгээг ашиглах боломжийг зааж өглөө. Дашрамд дурдахад, "СИТИ" Их

сургуулийн номын сан нь 8,331 төрлийн 17,564 ширхэг ном, 291 төрлийн 201 ширхэг эрдэмийн ажил, 99 төрлийн тогтмол хэвлэлийн 113 дугаар, 358 нийтлэл, 417 вэб материалыг бүрдүүлжээ. Номын сангийн үйлчилгээндээ их дээд сургуулийн номын сангуудад зориулагдсан "Lib4U" үүлэн програм ашигладаг учраас багш, ажилчид, оюутан залуучууд хүссэн газраасаа ном, сэтгүүл, эрдэм шинжилгээний өгүүлийг унших боломжтой юм.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 032 ДУГААР АНГИЙН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧИД, ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАД "УРЛАГ ГЭЖ ЮУ ВЭ?" СЭДЭВТ ЛЕКЦ УНШИВ



"СИТИ" Их сургуулийн Урлагийн сургуулийн Ярих урлагийн тэнхимийн багш М.Цолмонсүрэн Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн ажилтан, албан хаагчид болон хугацаат цэргийн алба хаагчдад зориулан

"Урлаг гэж юу вэ?" сэдэвт лекцийг амжилттай зохион байгууллаа. Энэ үеэр Жүжиглэх урлагийн 16 курсийн оюутнууд цэргүүдэд урлагийн тоглолт толилуулсан юм.

"АЗИ СУДЛАЛ-ХИ" ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА

"СИТИ" Их сургуулийн Хүмүүнлэгийн сургууль "АЗИ СУДЛАЛ-ХИ" олон улсын эрдэм шинжилгээний хурлыг хамтран зохион байгуулж байна. Эрхэм багш, судлаач та бүхнийг энэхүү хуралд өргөнөөр оролцохыг урьж байна.

СЭДВИЙН ХАМРАХ ХҮРЭЭ:

Япон, Солонгос, Хятад, Турк судлалын чиглэлээр дараах сэдвүүдийн хүрээнд байх:

- Хэл шинжлэл, утга зохиол
- Олон улс, орон судлал
- Түүх, соёл судлал
- Нийгэм, улстөр, эдийн засаг
- Боловсрол судлал

Хэзээ: 2025.05.02

Хаана: ШУТИС, VIII байр, 12 давхар, хурлын заал

Хурлын хэл: Монгол, Англи, Араб, Орос, Солонгос, Турк, Хятад, Япон

Илтгэлийг бүрэн эхээр нь 2025.03.14-ний дотор ирүүлнэ.

ОЮУТАН СОЛИЛЦООНЫ "ЭРАСМУС" ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ

"СИТИ" Их сургууль Франц Улсын Ницца хотын Côte d'Azur-ийн их сургуультай хамтран "Эрасмус" олон улсын оюутан солилцооны төсөл 2024-2027 онд хэрэгжүүлж эхэллээ.

Солилцооны хөтөлбөрийн хүрээнд 2025-2026 оны хичээлийн жилийн I улиралд Côte d'Azur-ийн их сургуульд суралцах хүсэлтэй, "СИТИ" Их сургуулийн бакалавр, магистрын 1-2 оюутан шалгаруулна. Хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутан дараах материалыг бүрдүүлж, 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Гадаад харилцааны албанд ирүүлнэ үү.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- CV
- Өргөдөл
- Дүнгийн хуулбар
- Хамгийн сүүлд авсан дипломын хуулбар
- Гадаад хэлний түвшний гэрчилгээ (англи, эсхүл франц хэл B2 түвшний хүчинтэй сертификат)
- Паспортын хуулбар

Жич: Хугацаа хэтрүүлсэн материалыг хүлээн авахгүй.

"CITI NEWS"

ОЮУТНУУД БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



Шүүгчдийн холбооны Ахмадын дэд хорооноос Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хурлын танхимд "СИТИ" Их сургуулийн Хууль зүйн сургууль болон Хүмүүнлэгийн сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн оюутнуудтай дурсамж уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар Шүүгчдийн холбооны Ахмадын дэд хорооны гишүүн Д.Наранцэцэг "Шүүхийн тогтолцооны өнгөрсөндөө" сэдвээр илтгэл тавьж,

оюутнууд асуулт асууж, хариулт авсан юм. Тус уулзалтад Шүүгчдийн холбооны гүйцэтгэх захирал Т.Туяа, ахмад шүүгч А.Мөнхзул, туслах Б.Жавзандулам, "СИТИ" Их сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн багш М.Наранчимэг, Хууль зүйн сургуулийн багш Э.Нямсүрэн нар оролцсон юм. Уулзалтын дараа оюутнууд Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн үйл ажиллагаатай танилцлаа.

"ОЛОН УЛСЫН ХУРАЛ УУЛЗАЛТ, ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭ: БЭЛТГЭЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТУРШЛАГА" СЭДЭВТ ЛЕКЦ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



"СИТИ" Их сургуулийн Бизнесийн сургуулиас Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, "Дипломат академ"-ийн орлогч захирал Г.Жаргалсайханыг урьж, "Олон улсын хурал уулзалт, ёслолын арга хэмжээ: Бэлтгэл, зохион байгуулалтын туршлага" сэдэвт лекцийг амжилттай зохион байгууллаа. Энэхүү лекц нь олон улсын харилцаа, дипломат үйл ажиллагааны үндсэн зарчим, арга барилыг ойлгох чухал ач холбогдолтой байв. Лекцийн үеэр Г.Жаргалсайхан олон улсын арга

хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалт, соёлын ялгааг ойлгож харилцах чухал арга замуудын талаар өөрийн туршлагаасаа хуваалцлаа. Тэрээр элчин сайдын үүрэг хариуцлага, олон улсын хурал, уулзалтуудыг үр дүнтэй зохион байгуулахад тулгардаг бэрхшээл болон тэдгээрийг даван туулах арга замыг тодорхой жишээнүүдээр тайлбарласан нь оролцогчдын анхаарлыг ихээхэн татав. Энэ үеэр түүнээс оюутнууд асуулт асууж, хариулт авсан юм.

"СИТИ" ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ ЭРХЭЛСЭН ЗАХИРАЛ Ж.ТЭМҮҮЖИН ШУТИС-ИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОРЫН ДИПЛОМОО ГАРДАН АВЛАА



"СИТИ" Их сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал Ж.Тэмүүжин өнөөдөр ШУТИС-ийн хүндэт профессорын дипломоо албан ёсоор гардан авлаа. Үүний зэрэгцээ, тэрбээр БНХАУ, Канадын судлаачидтай хамтарсан багийн гишүүнээр ажиллаж, "СИТИ" Их сургуулийн нэр дээр оролцсон

судалгааны өгүүлэл нь 3.7 импакт фактортой, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Chemical Engineering Research and Design сэтгүүлд хэвлэгдэхээр боллоо. Энэхүү нэр хүндтэй сэтгүүлийг олон улсын Elsevier компани эрхлэн гаргадаг билээ.

ЭМЭГТЭЙ ОЮУТНУУДАД ЗОРИУЛСАН ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



"СИТИ" Их сургуулийн Гоо сайхны ухааны сургуулийн "ГОО ЕРТӨНЦ" клуб нь "LADY" брэндтэй хамтран эмэгтэй оюутнуудад зориулсан өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр:

- "Lady" брэндийн менежер О.Батдорж "Охидын ариун цэврийн хэрэглээ" сэдвээр илтгэл тавьж, хэрэгтэй мэдээллүүдийг хүргэлээ.
- Гурван гал эмнэлгийн эх баригч, эмэгтэйчүүдийн эмч Л.Сэржготов "Нөхөн үржихүйн эрүүл мэнд"-ийн талаар оюутнуудад үнэ цэнэтэй зөвлөгөө өглөө.
- Арьс гоо заслын багш

Г.Гандиймаа "Амны маскыг зөв зүүх, халдвар хамгааллыг сахиж зөв хаях, ариун цэврийн хэрэглэлийг зөв хаях" тухай зөвлөмжийг оюутнуудад хүргэлээ.

Өдөрлөгт оролцсон оюутан бүрт амны маск болон ариун цэврийн хэрэглэл бэлэглэж, А байрны 1 давхарын ариун цэврийн өрөөнд LADY хайрцаг байрлууллаа. Түүнчлэн Гоо сайхны ухааны сургуулийн Арьс гоо засал, Үсчин стилистийн III курсийн оюутнууд "Гоо сайхны бүтээгдэхүүн судлалын хими" хичээлийн үзэсгэлэн гаргаж, өөрсдийн хийсэн гоо сайхны бүтээгдэхүүнээ танилцууллаа.